



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2012 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Телевизийн шууд нэвтрүүлэг явуулах
тухай

Монгол Улсын "Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-ийн заалтыг үндэслэн ТУШААХ нь.

Нэг. Иргэдийн оролцоо- Өрхийн хөгжлийг дэмжих жилийн ажлын зорилтод бэлэг дурсгалын үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдийг аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцуулах, дэмжлэг үзүүлэх гэсэн заалтын дагуу зохион байгуулагдсан "Үнэгүйдсэн Монгол брэнд буюу гар урчуудын ганцаардал" нээлттэй хэлэлцүүлгийн дүнг нэгтгэн, гар урлалын үйлдвэрлэл эрхлэгчдийн тулгамдсан асуудлуудыг хэрэгжүүлэх боломжтой юу гэдгийг хөндсөн телевизийн шууд нэвтрүүлэг зохион байгуулахыг мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/-д үүрэг болгосугай.

Хеёр. Телевизийн шууд нэвтрүүлэг явуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Телевизийн шууд нэвтрүүлэг явуулах төсөв болох 500.000 /таван зуун мянга/ төгрөгийг төрийн өмнөх ажил үйлчилгээний зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Телевизийн нэвтрүүлгийг цаг хугцаанд нь зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/-д даалгасугай.

ДАРГА



Ш.СҮХБААТАР

11505000052



Нийслэлийн аялал жуулчлалын газрын даргын 20.12.20 нь 09 сарын 26 өдрийн 15 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

ТЕЛЕВИЗИЙН ШУУД НЭВТРҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Зорилго:

Жил бүрийн 9-р сарын 27-ны өдөр дэлхийн аялал жуулчлалын өдөр тохиодог. Энэ өдрийг хүрээнд нийслэлийн Аялал жуулчлалын газраас олон арга хэмжээ зохион байгуулж ирсэн уламжлалтай. Энэ жилийн тухайд гар урчуудын бүтээгдэхүүнийг аялал жуулчлалын салбарт оновчтой хөгжүүлэх, тулгамдаад буй асуудлуудыг шийдэх гарцыг хайхад чиглэгдсэн ажлуудыг хийж байна. Энэ ажлын хүрээнд нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран “Үнэгүйдсэн Монгол брэнд буюу гар урчуудын ганцаардал” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Энэхүү хэлэлцүүлгийн дүнг нэгтгэн, гар урчуудын тулгамдаад буй асуудлууд шийдэгдэх үү гэдгийг харуулах зорилготойгоор телевизийн нэвтрүүлэг хийж байна. Гар урлалын үйлдвэрлэл эрхлэгчдийн тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлэх гарцыг хайх, энэхүү асуудлыг олон нийт, төр засгийнханд хүргэх, гар урлалын үйлдвэрлэл эрхэлдэг байгууллага болон иргэдийг аялал жуулчлалын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, бэлэг, дурсгалын чанарыг сайжруулах, нэр төрлийг олшруулах, аялал жуулчлалын салбараас иргэд ашиг олох боломжийг нээхэд телевизийн нэвтрүүлгийн зорилго мөн чиглэгдэнэ.

Нэвтрүүлгээр хөндөх асуудал:

-Юуны түрүүнд гар урлалын салбарт ажиллах боловсон хүчин гэж байдаггүй. Өнөөдөр монголын ажиллах хүчин уул уурхай эсвэл гадаад руу зорьж байна. Залуучуудыг энэ салбар руу чиглүүлэх хэрэгтэй байна.

-Гар урлалын бүтээлийг чанаржуулах шаардлагатай. Үүний тулд дээр өгүүлсэн боловсон хүчнээс гадна гар урлалын үйлдвэрлэлд стандарт үгүйлэгдэж байна. Тухайлбал, нэг модон хүүхэлдэйг арван янзаар хийж байна. Тэгвэл энэ хүүхэлдэйг нэг л янзаар чанарын өндөр түвшинд хийх стандартыг тогтоох.

Түүнчлэн гар урлалын салбарт мэргэжлийн дизайнер хэрэгтэй байна.

-Бүтээгдэхүүнээ үйлдвэрлэсний дараа борлуулах гарцыг олоход хүнд байдаг. Нэг ёсондоо энэ салбарт нарийн судалгаа, менежмент дутагдаж байна.

-Үйл ажиллагаагаа өргөтгөх, гадаад худалдаагаа хөгжүүлэхээр зээл авъя гэхэд арилжааны банкуудаас тавьж байгаа шалгуур өндөр. Барьцаа хөрөнгө шаарддаг. Барьцаа хөрөнгийг 50 хувиар үнэлээд 70 хувьд нь зээл олгоно гэдэг. Энэ салбарт итгэлцлийг барьцаалж болохгүй юу гэсэн асуудлыг гар урчууд тавьж байна.

Нэвтрүүлэгт санал авах иргэд:

д/д	Ямар байгууллага	Ярих асуудал	Холбоо барих утас
1	“Энхжин сувинер” Урьхан	Гар урлалын салбарт боловсон хүчин үгүйлэгдэж байна	70112999 99102999
2	“Монгол багц” Уранчимэг	Гар урчуудад нэгдсэн менежмент хэрэгтэй	99162699
3	“Актив адвенчур” Өнөр	Жуулчдыг гар урлалын чанартай бүтээгдэхүүнээр татах	99058467
4.	МҮХАҮТ-тай хамтран ажилладаг зөвлөх Stephen preppel	Монголын гар урчууд хөгжихийн тулд юу хийх ёстой вэ	324620 95051126

Нэвтрүүлэгт оролцож санал бодлоо илэрхийлэх байгууллагууд:

- Хөдөлмөрийн яам
- Соёл, спорт, аялал жуулчлалын яам
- Нийслэлийн Аялал жуулчлалын газар
- Сангийн яам
- Боловсрол, шинжлэх ухааны яам

Явуулах хугацаа:

2012.09.28-ны өдрийн 18.10 цагт

Хаана болох:

Монголын Үндэсний олон нийтийн телевизийн “Олон нийтийн цаг” нэвтрүүлэг



Нийслэлийн аялал жуулчлалын газрын даргын 20 ~~12~~ ¹⁰нь 09 сарын 26 өдрийн 45 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ТЕЛЕВИЗИЙН НЭВТРҮҮЛГИЙН ТӨСӨВ

д/д	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ 30 минут	Бүгд үнэ / төгрөг/
1	Захиалгат нэвтрүүлэг Монголын үндэсний олон нийтийн телевиз	1	500,000	500,000

Удирдамж боловсруулсан:

Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн

Ш. Ундармаа

Ш.Ундармаа

Хянасан: Ахлах ня-бо

П.Ариунаа

П.Ариунаа